

БНХАУ-ЫН БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ БА ХҮНИЙ НӨӨЦИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Ч.Батцэцэг*

Хятад улс нь боловсрол бол улс үндэстний амин сүнс гэж үздэг. Өнгөрсөн 30-аад жилийн турш БНХАУ эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэхийн сацуу хүн ардаа хөгжүүлэхийн тулд хүн ардаа бичиг үсэгтэй, боловсролтой болгохоор боловсролын салбарын шинэчлэлийг эрчимтэй явуулж байгаагийн үр дүнд хятадын ард түмний боловсролын төвшин харьцангуй түргэн дээшилж байна. Гэвч боловсролын салбарыг хөгжүүлэх шинэчлэх явц амаргүй, ялангуяа хөдөө тосгодын хүн ардын бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгах, бүх нийтээрээ зайлшгүй эзэмших ерөнхий боловсрол, дээд боловсрол, мэргэжлийн боловсролын асуудалд төвөгтэй, хүндрэл бэрхшээл зэрэг асуудал тулгарсан хэвээр байгаа ажээ. Боловсролын салбарт өөрчлөлт шинэчлэлийн ажлыг эхлүүлснээс хойш өнөөгийн байдлаар, Хятадын нийт хүн амын дундаж үзүүлэлтээр 15-аас дээш насныхан дунд сургуулийн 4,8 дугаар ангийн боловсролтой болжээ. Мөн 70 сая гаруй хятад хүн дээд боловсрол эзэмшсэн байна. Энэ үзүүлэлтийг *БНХАУ нь хүн ам олонтой их гүрнээс сайтар бэлтгэгдсэн мэргэжилтэнтэй их гүрэн руу шилжих шилжилтийн түүхэн үе руу орж байна гэж тодорхойлж¹* байгаа юм байна.

Хятад улс бараг сүүлийн 20-иод жилийн турш бүх нийтийг 9 жилийн суурь боловсрол эзэмшүүлэх сургалтыг хэрэгжүүлэх замыг туулж ирсэн. Энэ замыг хөгжиж буй орнууд бараг зуугаад жил туулж байгаа юм байна. Үүнийг дэлхийн түүхэнд авч үзвэл Хятадын боловсролын салбарын энэ амжилтыг үнэхээр гайхамшиг хэмээн тодорхойлдог аж. Хятад улс 1986 онд бүх нийтийн 9 жилийн суурь боловсрол эзэмших тогтолцоо, тодорхой зорилтын тухай хууль тогтоолыг БХАТИХ-аас баталснаас хойшхи үеийг *Хятадын боловсролын салбарын хөгжлийн шинэ үе шат эхэлсэн* хэмээдэг. Шинэ мянганы эхээр Хятад улс өөрийн амлалтаа биелүүлж, хүн амаа бүх нийтийн 9 жилийн суурь боловсрол эзэмшүүлэх сургалт явуулж буйгаа дэлхий дахинд зарласан билээ. Ингээд дунд сургуульд элсэж орох хүн амын коэффициент 85%-иар нэмэгдэж, энэ үзүүлэлтээр дэлхийн хүн ам ихтэй, хөгжиж буй орнуудаас Хятад улс тэргүүлэх байр эзлэх боллоо.

21-р зуунд БНХАУ нь хүн ардаа бүх нийтийн 9 жилийн суурь боловсролтой болгоход чиглүүлсэн үйл ажиллагаагаа улам идэвхжүүлэн чанаржуулж, шинэ түвшинд гаргахаар төлөвлөсөн байна. Тухайлбал, 2007 оны байдлаар Хятадын бүх нийтийн 9 жилийн суурь боловсрол эзэмшсэн хүн амыг хамарсан коэффициент 99,3%, хөдөө гацааны хүн амын коэффициент 98,5%-ийн үр дүнд хүрчээ. Ерөнхий суурь боловсролын сацуу техник мэргэжлийн боловсрол түргэн хөгжжээ. Мөн онд техник мэргэжлийн боловсролын сургуульд 8,1 сая

* Ч.Батцэцэг – ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хүн элсэж орсон нь бараг дунд сургуулийн ахлах ангийн сурагчдын тоотой тэнцэж байжээ.

Хятадад өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого явуулж эхэлсэн үеэс их дээд сургуульд элсэн суралцах элсэлтийн шалгалт /конкурс/ өгөх нь амьдралын чухал үйл явдалд тооцогдох болсон юм. 1999 онд их дээд сургуулийн байрны тоо нэмэгдсэн тэр үеэс Хятадад дээд боловсрол маш түргэн хугацаанд бүх нийтийнх болжээ. 1978-2008 онд их дээд сургуульд элсэлтийн шалгалт өгсөн хүний нийт тоо ойролцоогоор 128 саяд хүрч, тэдгээрээс 53,9 сая хүн элсэн орсон гэсэн мэдээлэл байна. 2007 оны байдлаар Хятадын их дээд сургуульд 27 сая хүн суралцаж байгаа гэсэн тоон үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх болж, их дээд сургуулийн элсэлтийн коэффициент 23%-ийг бүрдүүлсэн байна.²

Нөгөөтэйгүүр БНХАУ нээлттэй бодлого явуулснаар хятадын оюутнуудад гадаад ертөнцтэй танилцах боломжийг нээж өгчээ. Тухайлбал: 1978-2007 онд хилийн чанадад боловсрол эзэмшсэн хятад оюутны ерөнхий тоо 1,2 саяд хүрчээ. Хэрэв 1978 онд зөвхөн 860 хүн гадаадад суралцахаар явж байсан бол 2007 он гэхэд 144,5 мянган хүн болсон байна. Ийнхүү өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд энэ тоо 168 дахин өссөн бөгөөд гадаадад их дээд сургуульд суралцаж төгсгөсөн, нарийн мэргэжил эзэмшсэн тэдгээр хүмүүсийг эх орондоо эргэн ирж ажиллах, хөрөнгө оруулалт хийх таатай нөхцлийг бүрдүүлэхэд Хятадын засгийн газраас ихээхэн анхаарал тавьж байдаг.

Ийнхүү БНХАУ бүх ард түмнийг ерөнхий суурь боловсролтой болгох зорилт тавихаас гадна боловсролын чанарыг дээшлүүлэх талаар дорвитой арга хэмжээ удаа дараа авсаар байгаа юм. Үүний нэг жишээ бол 1999 онд БНХАУ-ыг хөгжүүлэх чухал зорилтуудын жагсаалтанд боловсролын чанарыг дээшлүүлэхтэй холбогдуулан бүх нийтээрээ эзэмших суурь боловсролын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах тухай заалтыг оруулжээ. Улмаар 2001 оноос боловсролын сургалтын хөтөлбөрт заавал суралцах хичээлүүдэд шинэчлэл хийж эхэлсэн аж. Ялангуяа БНХАУ-ын баруун, зүүн бүсийн хооронд, хот хөдөөгийн хоорондох боловсролын түвшний ялгааг багасгахын тулд БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс Хятадын баруун бүсийн нутагт насанд хүрэгсэд болон өсвөр насны залуусын дунд бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгаж суурь боловсрол олгох явдлыг 2004 оноос эхэлж 4 жилийн хугацаанд төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. 2007 оны сүүлч гэхэд энэ төлөвлөгөөний хүрээнд баруун бүсийн хүн амын бараг 98% хамрагдсан байв.

2006 оноос хөдөөгийн суурин газруудад бүх нийтийн суурь боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг, бололцоогоор хангах аргачлалыг явуулсны үр дүнд 400 мянга гаруй сургууль буюу хөдөөгийн бага, дунд сургуулийн 150 сая сурагч улсын төсвөөс санхүүжилт авчээ. Үүнээс улбаалан БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс 2008 оны хичээлийн шинэ жилээс бүх нийтийн суурь боловсрол эзэмших шатанд сургалтын болон сурагчийн зардлыг бүрэн халах тогтоол шийдвэр гаргав. Энэ бодлого одоо Хятад улс даяар амжилттай хэрэгжиж, хотын бүх нийтийн ерөнхий боловсролын 25,9 мянган сургууль,

хотын 28,2 сая сурагчдад ашиг тусаа өгсөөр байна. Мөн бодлогын хүрээнд амьжиргааны төвшин харьцангуй доогуур, боломж багатай айл өрхийн оюутан хүүхдэд дээд боловсрол эзэмших үед улсаас хангамж тэтгэлэг олгох тогтолцоог бий болгож, улсаас оюутны цалин олгох, амжилттай суралцаж буй оюутанд нэмэлт урамшуулал өгөх, сурган хүмүүжүүлэх тэнхимд төлбөргүй сургах зэрэг олон хэлбэрийн тэтгэлгийг бий болгожээ. Энэхүү тэтгэлгийн шинэ тогтолцоо нь боломж муутай, хангалуун бус айл өрхөөс техник мэргэжлийн сургуульд суралцагсдын бараг 90%-ийг хамарсан байна.

Нөгөөтэйгүүр сурагч, оюутныг бэлтгэхээс гадна багш нарын мэргэжил чадварыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарал тавьж ирсний үр дүнд БНХАУ-ын Боловсролын Яамны мэдээлснээр, 2006 онд хөдөөгийн сургуулийн багш нарын хичээлийн хуваарийн хөтөлбөр боловсруулж, алслагдсан хөдөө тосгоныг чадварлаг, сайн багш нараар бэхжүүлжээ. Ингээд зөвхөн 2007 онд гэхэд л Хятадад мэргэжил дээшлүүлсэн багш нарын тоо 19,6 саяд хүрсэн байна. Мэргэжил дээшлүүлсэн багш нарын коэффициентээс харахад, анхан шатны бага сургуулийн багш 99,1%, дунд сургуулийн багш нар 97,2%, ахлах сургуулийн багш нар 89,3%-ийг эзэлж³ байв.

2010 онд БХАТИХ-ын 11 дэх удаагийн 4 дүгээр чуулганаас боловсролын салбарт зориулж 254,734 тэрбум юань буюу төсвийн зардлын үзүүлэлтийг 117,9 хувиар тооцоолж байсан бол 28,6 хувиар нэмэгдсэн байна. Хөдөө тосгоны ерөнхий боловсролын сургуулиудын санхүүгийн хангамжийн механизмын гүйцэтгэлд 73,18 тэрбум юань хуваарилснаар хөдөө тосгоны 130 сая сурагч заавал эзэмших суурь боловсролын сургалтын төлбөрөөс чөлөөлөгдсөн төдийгүй сурах бичгээ үнэгүй авчээ. Мөн түүнчлэн сургуулийн дотуур байранд байдаг төвийн болон баруун бүсийн хөдөө тосгодын ядуу айлын ойролцоогоор 12,28 сая хүүхэд мөнгөн тэтгэлэг авч, хотын сургуулийн 29 сая сурагч сургалтын төлбөрөөс чөлөөлөгджээ. Алслагдсан хөдөө тосгоноос ирсэн техник мэргэжлийн дунд сургуулийн ялангуяа хөдөө аж ахуйн чиглэлээр суралцаж буй 4,4 сая сурагч сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөж, тэдгээр сургууль, сурагчдын цалинд 20,909 тэрбум юань хувиарилсан байх юм.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын их дээд сургуулиудад хэрэгжүүлж байгаа “Хөтөлбөр-211”, “Хөтөлбөр-985” гэсэн программ нь их дээд сургууль болон эрдэм шинжилгээ-судалгааны байгууллагуудыг дэлхийн түвшинд гаргахад чухал түлхэц болно гэж үзжээ. Дээрхи хөтөлбөрүүдийг шинэ шатанд гаргаж идэвхжүүлэхийн тулд их дээд сургуулиудад заах аргыг шинэчлэх, чанарын шинэ түвшинд гаргахад зориулж улсаас 2010 онд 60,663 тэрбум юань хуваарилж, орон нутгийн их дээд сургуулийн хөгжил шинэчлэлд дэмжлэг болгохоор 20,067 тэрбум юань олгосон байна. Үүний үндсэн дээр Хятадын нийгмийн хүрээнд хувийн их сургууль болон эрдэм шинжилгээ-судалгааны газруудыг байгуулах бэлтгэл ажил биелэлээ олж байгаа ажээ. Ингэснээр аспирантуудын тоо 5 дахин өсч, эрдэм шинжилгээ судалгааны газруудад хуваарилсан хөрөнгө мөнгө 7 дахин, шинжлэх ухааны докторын зэрэгтэй багш нарын тоо ойролцоогоор 5

дахин нэмэгдэж, эрдэм шинжилгээний техник-тоног төхөөрөмжийн нийт өртөг 4 дахин нэмэгдсэн гэсэн тоо мэдээлэл байна.

Ийнхүү Хятад улс нэн тэргүүнд боловсролын салбарын өөрчлөлтийг чухалчлан “БНХАУ-ын Боловсролын салбарын өөрчлөлт шинэчлэлийн дунд болон урт хугацааны хөгжлийн хэтийн төлвийн үндсэн зарчмууд”-ыг батлан гаргалаа. Энэхүү “БНХАУ-ын дунд болон урт хугацааны боловсролын өөрчлөлт шинэчлэл хийгээд хөгжлийн хэтийн төлвийн үндсэн зарчмууд /2010-2020/” гэсэн хөтөлбөрийг батлахын тулд холбогдох газрын мэргэжилтэн, эрдэмтэн, багш нараар урьдчилан хэлэлцүүлж, саналыг нь авч засвар оруулжээ. Улмаар 2010 оны 5 дугаар сард 4 албан ёсоор батлан тунхаглаж БНХАУ-ын Боловсролын салбарыг бүх талаар өөрчлөн шинэчлэх ажлыг эхлүүлжээ. Ийнхүү БНХАУ-ын төр засгаас хүн ардаа бичиг үсэгтэй улмаар эрдэм боловсролтой болгохын төлөө уйгагүй ажиллаж байгаа хэдий ч Хятадын хүн ам их, газар нутаг том учраас төр засгийн газраас явуулж буй шинэчлэлийн бодлого, авч байгаа арга хэмжээ зах хязгаарын алслагдсан бүс нутаг хөдөө тосгонд тэр бүр хүрч, төдийлөн хэрэгждэггүй болохоор бичиг үсэггүй, эрдэм мэдлэггүй, боловсролгүй тариачид олноороо хэвээр байна

Нөгөөтэйгүүр өнөөдөр Хятадад орчин үеийн техник технологийн нарийн мэргэжлийн, өндөр боловсролтой боловсон хүчний асуудал хурцаар тавигдаж байгаа. Иймд 21 дүгээр зууны шилдэг мэргэжилтнийг бэлтгэхэд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулж, чиглэл чиглэлээр гадаад дотоодод бэлтгэж эхлээд байна.

БНХАУ нь мэргэжлийн боловсон хүчин бол тэргүүн баялаг, үндэсний хөгжлийн стратегийн баялаг юм гэж үзэж байна. Ялангуяа бүх салбарт шилдэг чадварлаг хүмүүсийг төрүүлж, бүх салбарыг эрдэм мэдлэгтэй тэргүүний боловсон хүчнээр бэхжүүлж, тэднийг ёс суртахуун, эрдэм мэдлэг, чадвараар шалгаруулж, шинийг бүтээхийг эрэлхийлүүлэх, шилдэг залуу боловсон хүчнийг бэлтгэн хүмүүжүүлэх чиг хандлагыг баримтлах болов. Ингээд БНХАУ нь стратегийн хөгжлийн хөтөлбөрийг салбар чиглэл тус бүрээр боловсруулан гаргасан байна. Тухайлбал: эрдэм боловсролтой, ур чадвартай боловсон хүчнийг бэлтгэх тухайд, хүний нөөцийг хамгаалах, хангах асуудлыг дэвшүүлж, бодитоор хэрэгжүүлэх тухай зүйлт заалтыг “БНХАУ-ын дунд ба урт хугацааны шинжлэх ухаан техникийн хөгжлийн хэтийн төлөвийн үндсэн зарчмууд”⁵ гэсэн хөтөлбөрт тусгасан байна. Үүнд: дэлхийд тэргүүлэх, өндөр зэрэглэлийн, дээд түвшний хэсэг бүлэг мэргэжилтэнг түргэн хугацаанд бэлтгэж сургах, хүний нөөцийг шинээр бэлтгэж сургахын тулд боловсролын асуудлыг чухалчлах, улмаар үйлдвэр аж ахуйн газруудад шинжлэх ухаан техникийн ажилтны нөөцийг татан оруулахыг дэмжих, үйлдвэр аж ахуйн газруудад гадаадын эрдэмтэн, инженерийг урьж ажиллуулахыг дэмжих тухай оржээ.

Хятад улс нь мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх ажлыг хийхдээ олон хэлбэрийн арга хэмжээ авч байна. Ялангуяа залуу мэргэжилтнийг гадаад дотоод явуулж сургахаас гадна дэлхийн хамгийн шилдэг мэргэжилтнийг урьж ажиллуулахын сацуу тэднийг дагалдуулан сургах ажлыг чухалчилж байна.

БНХАУ-ын Гадаадын мэргэжилтнүүдийн хэргийг эрхлэх улсын удирдах газрын орлогч дарга Лю Янгуо “China Daily” сонинд өгсөн ярилцлагадаа, БНХАУ-д одоо Хятадын шинжлэх ухааны болон аж ахуйн төрөл бүрийн салбарт гадаадын мэргэжилтнүүдийг татан оролцуулах кампанит ажлыг маш өргөн хүрээтэй, бүх сувгаар идэвхтэй явуулж байгааг онцлон тэмдэглэсэн байна. Энэ төсөл 10 жилийн хугацаатай хэрэгжиж, дэлхийн өнцөг булан бүрээс өндөр мэргэшлийн 1000 мэргэжилтнийг урьж авчирахаар тооцоолжээ. Энэ Хөтөлбөр 2011 оноос эхэлсэн бөгөөд одоогоор 40 мэргэжилтнийг урьсанаас 30 нь ажилдаа ороод, бусад нь сонгон шалгаруулалтын түвшинд байгаа юм байна. Хилийн чанадаас ирэх мэргэжилтнүүд үндсэндээ хими, байгаль экологи, инжениринг, эрчим хүч, биологийн шинжлэх ухаан, болон бизнес удирдлагын салбар хүрээнд мэдлэг чадвараа түгээх ёстой. Хятадад ажиллахаар нэрээ дэвшүүлж буй хүмүүсийг маш өндөр шалгуураар авч байгаа ба 65 хүртэлх насны хүмүүс Хятадад 3-аас доошгүй жил ажиллах боломжтой юм байна. Нөгөөтэйгүүр Хятад улстай эдийн засаг, технологийн чиглэлээр нягт хамтран ажилладаг Америк, Япон, Их Британи, Герман, ОХУ-аас мэргэжилтнүүдийг авахыг ихээхэн сонирхож байгаа ажээ. Ийнхүү дэлхийн хамгийн шилдэг мэргэжилтнийг урьж ажиллуулснаар Хятадын эдийн засгийг шинэ түвшинд гаргаж ирэх боломжтой хэмээн үзэж байна.

Эцэст нь БНХАУ-ын эдийн засаг үсрэнгүй хөгжиж, эдийн засгийн суурь нэгэнт бэхжиж, олон улсын тавцанд нэр хүнд нь өсч байгаа өнөө үед нэг талаас ард түмнээ бичиг үсэгтэй, боловсролтой, эрдэм мэдлэгтэй болгож улмаар дэлхийн их гүрний хүнийг бэлтгэж хөгжүүлэх, нөгөө талаас бичиг үсэггүй, мэргэжил боловсролгүй олон сая тариачдын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нөр их ажил Хятадын удирдлагын өмнө тулгараад байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ <http://www.gov.cn.jrzg /2010/ content>

² [www.edu.cn \(html/e/jiaoyu guihua gangyao.html/](http://www.edu.cn (html/e/jiaoyu guihua gangyao.html/)

³ baike.baidu.com /view/.

⁴ 国家教育改革将全面启动 欲扭转教育分配局面

2010-05-05 05:01 来源:中国经济网 我说两句(34条评论)

⁵ <http://www.gov.cn.jrzg /2010/ content>

⁶ 国家教育改革将全面启动 欲扭转教育分配局面

2010-05-05 05:01 来源:中国经济网 我说两句(34条评论)